

Стандартын төсөлд санал авах тухай

Харилцаа холбооны зохицуулах хороо нь Харилцаа холбооны тухай хуулийн 9.1.8-д заасан чиг үүргийн хүрээнд дараах стандартуудад өөрчлөлт оруулах төслийг боловсруулан батлуулах ажлыг зохион байгуулж байна. Үүнд:

- MNS 5380-2:2004 Шуудангийн хэрэглэгдэхүүн 2-р хэсэг: Шуудангийн маягт
- MNS 5539:2019 Шуудангийн аюулгүй байдал

Та саналаа 2026 оны 07 дугаар сарын 10-ны дотор саналаа бичгээр эсвэл info@crc.gov.mn, narantsetseg@crc.gov.mn хаягаар ирүүлнэ үү.

“MNS 5380-2:2004 Шуудангийн хэрэглэгдэхүүн 2-р хэсэг: Шуудангийн маягт”

5.5.Шуудангийн илгээмжийн зураасан код

5.5.1. Шуудангийн илгээмжийн үнэ төлөгдсөнийг баталгаажуулан марк наахын оронд зураасан кодыг нааж болно.

5.5.2. Зураасан кодыг илгээгчийн хаягийг дээд болон доод талд нааж болно

5.5.3. Уг кодыг шуудангийн илгээмжийн бүртгэл, хяналтын системд оруулан тухайн илгээмжийн хүргэлтийн талаарх мэдээллийг хянаана.

5.5.4. Зураасан код нь олон улсын шуудангийн байгууллагуудын хэрэглэж байгаа техник хэрэгсэлд тохирсон байх шаардлагатай.

5.5.6. Улс хоорондын энгийн, буухиа бичиг захидал дээр илгээгчийн болон хүлээн авагчийн хаягаас гадна зураасан код, мөн гаалийн мэдүүлгийн маягтыг үнэн зөв бичиж наана.

5.5.7. Улс хоорондын шуудангийн боодол, илгээлтэнд зураасан код бүхий хаягийн Маягт:2026 маягтыг наана.

5.5.8. Уг маягт нь илгээгчийн болон хүлээн авагчийн хаяг, илгээлтэнд агуулагдаж байгаа зүйлсийн дэлгэрэнгүй жагсаалт, үнийн дүн, тоо ширхэг, жин, төлбөрийн хэлбэр, гардуулагдаагүй тохиолдолд өгөх заавар, тээвэрлэлтийн төрөл, даатгасан эсэх талаарх мэдээлэл, огноо, илгээгчийн гарын үсэг ба шуудангийн хураамжийн талаарх мэдээлэл бүхий гаалийн мэдүүлгийг агуулсан байна. Мөн (Хавсралт А.5.1-р зураг Маягт: 2026 маягтыг үзүүлэв).

5.5.9. Зураасан код бүхий хаягийн шошгыг хэрэглээгүй тохиолдолд шуудангийн байгууллага илгээлтийг битүүмжилсэн хайрцаг, саван дээр албаны тэмдэглэл, өдрийн тэмдэг тавих зориулалтын зайг үлдээнэ.

Маягт : 2026

Name: FROM:		Name: TO:		Total gross weight
Address:		Address:		Postage rate
Postal code	Country	Phone Number	Country	Choose type of handling desired
Detailed description of content		Number of items	Country of origin of goods	
			Net weight Value gramm	<input type="checkbox"/> Surface / Газар
				<input type="checkbox"/> SAL / Хосолсон
				<input type="checkbox"/> Express
				<input type="checkbox"/> Advice of delivery
				<input type="checkbox"/> Хүлээн авагч төлөх
Total value of goods				
<input type="checkbox"/> Cross (X) if the item is insured	Insured value (words)	Insured value (numerals)	SDR	
INSTRUCTIONS TO BE GIVEN BY THE SENDER in case of non delivery of the parcel. Every parcel returned or redirected shall be subject to the postage rates entailed				Date mailed (yyyy/mm/dd)
<input type="checkbox"/> Return to origin immediately	<input type="checkbox"/> By air	Signature of sender		
<input type="checkbox"/> Return to sender after ____ days	<input type="checkbox"/> By surface / SAL			
<input type="checkbox"/> Treat as abandoned	<input type="checkbox"/> Deliver to new address:			
<input type="checkbox"/> Redirect Address: _____				

“MNS 5539:2019 Шуудангийн аюулгүй байдал”

6.7.6 /CN22 ба CP72/-ын гэснийг /CN22 ба CP72 г.м/ гэж өөрчлөх.